



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/652

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 42 дугаар зүйлийн 42.2.1.в, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Автозамын сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн татварын хэлтсийн гаднах зогсоол, аюулгүй тойргийн баруун урд талын замын ажлын зураг төсвийн зардал 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөг, Есөнзүйл сумын эрүүл мэндийн төвийн засварын зураг төсвийн зардал 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Ворлд мэл ХХК, Өсөх оргил прожект ХХК-уудтай тооцоо хийж, дээрх 6,400,000 (зургаан сая дөрвөн зуун мянга) төгрөгийн зардлыг техник хяналт, барьцаа хөрөнгийн данснаас шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

911101404